



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хангал сумын Хялганат тосгоны сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2021 /100/-СТА-ТШЗ**

---

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Цахим хаяг: [Ankhubayard@audit.gov.mn](mailto:Ankhubayard@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: П.Содном

Утас: 70342495

Цахим хаяг: [Sodnomp@audit.gov.mn](mailto:Sodnomp@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	15
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	15
4. Менежментийн захидал .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	<b>Error! Bookmark not defined.</b>



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.25 № 108

Танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ Т

**ХАНГАЛ СУМЫН ХЯЛГАНАТ  
ТОСГОНЫ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ц.ЦОЛМОНБААТАР ТАНАА**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангал сумын Хялганат тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангал сумын Хялганат тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

006020227

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР



**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>60,783,961.00</b>	<b>80,676,616.91</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	60,783,961.00	80,676,616.91
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	3,109,140.00	4,637,770.00
35110	Тусгай зориулалттай материал	2,968,140.00	4,209,570.00
35130	Эм боох материал	141,000.00	428,200.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,762,586.00	4,727,586.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	52,912,235.00	71,311,260.91
35410	Бичиг хэргийн материал	19,408,838.00	22,630,684.91
35420	Аж ахуйн материал	22,418,827.00	23,268,572.00
35430	Сэлбэг хэрэгсэл	540,000.00	540,000.00
35460	Хүнсний материал	10,544,570.00	5,064,004.00
35470	Бусад хангамжийн материал	-	19,808,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,623,825,873.74</b>	<b>1,548,450,213.44</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,623,825,873.74	1,548,450,213.44
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,560,388,873.56	1,483,713,213.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,445,221,812.56	1,454,836,412.56
39202	Хуримтлагдсан элэгдэл	(67,393,274.10)	(133,538,214.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	238,491,055.05	188,501,730.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	(138,272,095.23)	(96,177,368.68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,295,216.06	78,160,046.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,877,615.78)	(25,063,822.72)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,228,875.00	4,228,875.00
39217	Ном	9,694,900.00	12,765,555.21
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	63,437,000.18	64,737,000.26
39301	Програм хангамж	250,000.00	1,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(74,999.82)	(124,999.74)
39303	Бусад биет бус хөрөнгө	63,262,000.00	63,262,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,684,609,834.74</b>	<b>1,629,126,830.35</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,684,609,834.74</b>	<b>1,629,126,830.35</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,684,609,834.74	1,629,126,830.35

**Хангал сумын Хялганат тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,345,438,447.10	2,345,438,447.10
51101	Өмч: - төрийн	2,282,176,447.10	2,282,176,447.10
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(923,013,501.94)	(978,496,506.33)
51210	Өмнөх үеийн үр дүн	(923,013,501.94)	(923,013,501.94)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(55,483,004.39)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	262,184,889.58	262,184,889.58
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,684,609,834.74</b>	<b>1,629,126,830.35</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,250,199,000</b>	<b>1,378,874,383.12</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,894,900.00</b>	<b>31,757,583.12</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	9,894,900.00	31,757,583.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,894,900.00	31,757,583.12
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,894,900.00	31,757,583.12
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,240,304,100</b>	<b>1,347,116,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	919,360,500.00	1,062,619,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	919,360,500.00	1,062,619,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	13,130,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,130,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	307,813,600.00	284,497,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	307,813,600.00	284,497,800.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>		-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,316,746,111.89</b>	<b>1,413,777,843.67</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,316,746,111.89</b>	<b>1,413,777,843.67</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,283,187,805.32	1,334,750,295.36
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	690,470,273.43	799,004,383.93
210101	Үндсэн цалин	488,827,828.00	549,325,105.56

Хангал сумын Хялганат тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210102	Нэмэгдэл	119,506,926.43	174,837,833.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	82,135,519.00	74,841,445.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>87,067,200.00</b>	<b>105,125,962.12</b>
210201	Тэтгэврийн даатгал	59,205,700.00	72,261,394.25
210202	Тэтгэмжийн даатгал	6,965,400.00	8,223,593.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,407,796.00	6,575,494.48
210204	Ажилгүйдлийн даатгал	1,557,604.00	1,642,345.64
210205	Эрүүл мэндийн даатгал	13,930,700.00	16,423,134.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>306,750,200.00</b>	<b>283,385,175.64</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,605,700.00	6,732,225.64
210302	Түлш, халаалт	284,449,700.00	263,958,150.00
210303	Цэвэр, бохир ус	12,694,800.00	12,694,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,113,659.00</b>	<b>13,114,230.00</b>
210401	Бичиг хэрэг	1,254,350.00	616,675.00
210402	Тээвэр, шатахуун	2,778,200.00	2,550,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	480,200.00	480,200.00
210404	Ном, хэвлэл	509,700.00	241,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	216,400.00	1,513,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,874,809.00	7,712,095.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>41,176,160.00</b>	<b>25,479,766.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	390,550.00	385,400.00
210502	Хоол, хүнс	40,184,550.00	23,451,166.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	601,060.00	1,643,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,063,400.00</b>	<b>964,400.00</b>
210604	Урсгал засвар	1,063,400.00	964,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,335,600.00</b>	<b>332,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,335,600.00	332,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,870,100.00</b>	<b>1,027,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,774,100.00	1,027,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>131,341,212.89</b>	<b>106,316,577.67</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,711,718.00	339,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,315,832.00	5,376,970.00

**Хангал сумын Хялганат тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	109,313,662.89	100,600,507.67
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>33,558,306.57</b>	<b>79,027,548.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>27,491,280.00</b>	<b>17,813,750.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,856,280.00	16,213,750.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,635,000.00	1,600,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>6,067,026.57</b>	<b>61,213,798.31</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,067,026.57	61,213,798.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>613,126,288.11</u></b>	<b><u>(34,903,460.55)</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	20,579,543.84
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	20,579,543.84
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(20,579,543.84)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>613,126,288.11</u></b>	<b><u>(55,483,004.39)</u></b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,240,304,100.00</u></b>	<b><u>1,347,116,800.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>1,240,304,100.00</u></b>	<b><u>1,347,116,800.00</u></b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	919,360,500.00	1,062,619,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	919,360,500.00	1,062,619,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	13,130,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,130,000.00	-
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	307,813,600.00	284,497,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	307,813,600.00	284,497,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,206,827,500.00</u></b>	<b><u>1,327,743,030.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>1,206,827,500.00</u></b>	<b><u>1,327,743,030.00</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>1,174,495,473.43</u></b>	<b><u>1,247,474,051.69</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b><u>690,470,273.43</u></b>	<b><u>799,004,383.93</u></b>
210101	Үндсэн цалин	488,827,828.00	549,325,105.56
210102	Нэмэгдэл	119,506,926.43	174,837,833.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	82,135,519.00	74,841,445.00

Хангал сумын Хялганат тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	87,067,200.00	105,125,962.12
210201	Тэтгэврийн даатгал	59,205,700.00	72,261,394.25
210202	Тэтгэмжийн даатгал	6,965,400.00	8,223,593.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,407,796.00	6,575,494.48
210204	Ажилгүйдлийн даатгал	1,557,604.00	1,642,345.64
210205	Эрүүл мэндийн даатгал	13,930,700.00	16,423,134.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	306,750,200.00	283,385,175.64
210301	Гэрэл, цахилгаан	9,605,700.00	6,732,225.64
210302	Түлш, халаалт	284,449,700.00	263,958,150.00
210303	Цэвэр, бохир ус	12,694,800.00	12,694,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,484,300.00	17,869,800.00
210401	Бичиг хэрэг	447,200.00	453,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,778,200.00	2,550,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	480,200.00	480,200.00
210404	Ном, хэвлэл	454,200.00	411,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	216,400.00	3,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,108,100.00	10,775,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	38,958,500.00	26,315,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	389,600.00	389,600.00
210502	Хоол, хүнс	36,676,600.00	17,970,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,892,300.00	7,954,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,063,400.00	1,063,400.00
210604	Урсгал засвар	1,063,400.00	1,063,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,335,600.00	332,000.00
210702	Дотоод албан томилолт	1,335,600.00	332,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,068,600.00	1,002,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,972,600.00	1,002,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	96,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29,297,400.00	13,375,530.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,698,850.00	9,880,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,598,550.00	3,495,530.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>32,332,026.57</b>	<b>80,268,978.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	26,265,000.00	19,055,180.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,630,000.00	17,455,180.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,635,000.00	1,600,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>6,067,026.57</b>	<b>61,213,798.31</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,067,026.57	61,213,798.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>33,476,600.00</u></b>	<b><u>19,373,770.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>33,476,600.00</b>	<b>19,373,770.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>33,476,600.00</b>	<b>19,373,770.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>33,476,600.00</b>	<b>19,373,770.00</b>
222001	Тоног төхөөрөмж	15,186,600.00	4,249,970.00
223001	Бусад хөрөнгө	18,290,000.00	15,123,800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(33,476,600.00)</u></b>	<b><u>(19,373,770.00)</u></b>
250005	Төлсөн ногдол ашиг		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>=</b>	<b>=</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	2,345,438,447.10	262,184,889.58	(856,466,390.05)	1,751,156,946.63
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,345,438,447.10</b>	<b>262,184,889.58</b>	<b>(856,466,390.05)</b>	<b>1,751,156,946.63</b>
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(66,547,111.89)	(66,547,111.89)
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,345,438,447.10</b>	<b>262,184,889.58</b>	<b>(923,013,501.94)</b>	<b>1,684,609,834.74</b>
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>2,345,438,447.10</b>	<b>262,184,889.58</b>	<b>(923,013,501.94)</b>	<b>1,684,609,834.74</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,345,438,447.10</b>	<b>262,184,889.58</b>	<b>(923,013,501.94)</b>	<b>1,684,609,834.74</b>
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(55,483,004.39)	(55,483,004.39)
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,345,438,447.10</b>	<b>262,184,889.58</b>	<b>(978,496,506.33)</b>	<b>1,629,126,830.35</b>

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1350072600.00	1285903001.69
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1350072600.00	1266529231.69
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1319519100.00	1247474051.69
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	815564600.00	799004383.93
210101	Үндсэн цалин	559849400.00	549325105.56
210102	Нэмэгдэл	171471700.00	174837833.37
210104	Урамшуулал	84243500.00	74841445.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	111339600.00	105125962.12
210201	Тэтгэврийн даатгал	77950000.00	59205700.00
210202	Тэтгэмжийн даатгал	8347400.00	6965400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6677900.00	5407796.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1669500.00	1557604.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16694800.00	13930700.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	286750200.00	283385175.64
210301	Гэрэл, цахилгаан	9200000.00	6732225.64
210302	Түлш, халаалт	264855400.00	263958150.00
210303	Цэвэр, бохир ус	12694800.00	12694800.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23929000.00	17869800.00
210401	Бичиг хэрэг	453200.00	453200.00
210402	Тээвэр, шатахуун	2550000.00	2550000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	480,200.00	480,200.00
210404	Ном, хэвлэл	411,400.00	411,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	3,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,834,200.00	10,775,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	52,273,500.00	26,315,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	389,600.00	389,600.00
210502	Хоол, хүнс	43,929,100.00	17,970,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,954,800.00	7,954,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,063,400.00	1,063,400.00
210604	Урсгал засвар	1,063,400.00	1,063,400.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	835,600.00	332,000.00
210702	Дотоод албан томилолт	835,600.00	332,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,829,100.00	1,002,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,155,100.00	1,002,800.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,350,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	24,934,100.00	13,375,530.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,134,600.00	9,880,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,799,500.00	3,495,530.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	30,553,500.00	19,055,180.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	30,553,500.00	19,055,180.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,953,500.00	17,455,180.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,600,000.00	1,600,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>19,373,770.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	19,373,770.00
222001	Тоног төхөөрөмж	-	19,373,770.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,350,072,600.00	1,285,903,001.69
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,062,259,000.00	1,001,405,201.69
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,062,259,000.00	1,001,405,201.69
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	287,813,600.00	284,497,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	287,813,600.00	284,497,800.00

### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хангал сумын Хялганат тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ц.Цолмонбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном нар хариуцаж хэрэгжүүлэв.

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1316746.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 26334.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55483.0 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Бараа материал	60783.9	80676.6	19892.6
Үндсэн хөрөнгө	1623825.9	1548450.2	-75375.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1684609.8</b>	<b>1629126.8</b>	<b>-55483.0</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1684609.8	1629126.8	-55483.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1684609.8</b>	<b>1629126.8</b>	<b>-55483.0</b>

Тайлант онд авлага үүсээгүй, үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 80676.6 мянган төгрөг болж 19892.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Бараа материал дансанд тайлант онд төсвийн хөрөнгөөр 74998.4 мянган төгрөг, хандив тусламжаар 5326.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, хорио цээр тогтоож үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой материалын үлдэгдэл нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1548450.2 мянган төгрөг болж 75375.7 мянган төгрөгөөр буурсан нь 36079.2 мянган төгрөгийн хөрөнгө акталжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 19373.8 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 5363.7 мянган төгрөг, үнэ тогтоолтоор 21066.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө 36079.2 мянган төгрөгийн хөрөнгө акталж хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 1350.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд программ хангамж нэмэгдсэн байна.

Өр төлбөр данс үлдэгдэлгүй, тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1629126.8 мянган төгрөг болж 55483.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 128675.4 мянган төгрөгөөр буюу 10.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан тусгай зориулалтын шилжүүлэг байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга нь хийгдээгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1372593.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1372593.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 22520.9 мянган төгрөгөөр бууруулж 1350072.6 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1350072.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 1062259.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 287813.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1062619.0, орон нутгийн төсвөөс 284497.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1285903.0 мянган төгрөгийг зарцуулж 61213.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар санхүүжилт аваагүй байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг хугацаанд нь шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд итгэл үзүүлсэн байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 22769.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 966.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 21802.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

## **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулга байхгүй байна.

## **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 966.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 966.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

1. Ном хэвлэлийн зардлаас 241.7, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 725.0 мянган төгрөг нийт 966.7 мянган төгрөгийг интернэтийн зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

## **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 21802.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Зардлын төлөвлөлт, бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан эсэх анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Зардлын данстай холбоотой асуудал*

1.1 Илрүүлэлт: Төсвийн тодотголоор урсгал завсрын зардлыг бараа үйлчилгээний бусад зардалд төлөвлөн зарцуулсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй." гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

1.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, зориулалт бус зардал гарах.

1.3 Өгсөн зөвлөмж: Хөтөлбөр арга хэмжээг зориулалтын дагуу төлөвлөж, батлуулан, зарцуулж байх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн.

*2. Дотоод хяналттай холбоотой асуудал*

2.1. Илрүүлэлт: Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас 2668.1 мянган төгрөгийг цалингийн зардалд бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.2. Эрсдэл: Хууль, журам зөрчигдөх, зориулалт бус зардал гарах.

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.5-дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах, төсвийн бүлэг хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлтэй танилцаж, зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ